**СЭЛЭНГЭ АЙМАГ УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН**
**2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 08 Сүхбаатар сум

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 1.1 Улсын сүлжээний ус, цаг уурын өртөө харуулуудын тасралтгүй ажиллагааг хангаж ус, цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрт ажлыг нэгдмэл арга зүйн дагуу хийж гүйцэтгэх | | | | | | | |
| 1.1.1 | Уур амьсгалын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай хийж гүйцэтгэх. | Улсын төсөв | УЦУОСМХ-ийн УАӨНС-ны хэлтсээс үнэлсэн ажлын үзүүлэлт - Хувиар | Ажиглалтын чанар-98,9<br>Шүүмжийн чанар-99,1 | Ажиглалтын чанар-98,8<br>Шүүмжийн чанар-98,2 | Цаг уурын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу хийж өртөө харуулуудын нийт 156 тайланд техник, шүүмж шалгалт хийж /ЦД-1 84 ширхэг, ЦД-7 72ширхэг, ЦД-5 56 ширхэг, ЦД-3 21 ширхэг, термо 2568 ширхэг, гигро 2568 ширхэг, баро 364 ширхэг өөрөө бичигчийн лентийг шалгаж сар бүрийн 02-ны дотор УЦУОСМХ-ийн цаг уурын секторт нийт 156 тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.<br>Өртөө, харуулын шинжилгээний ажлыг тайлангийн ирц, хөтөлбөрийн биелэлт, ажиглалтын чанар, материал боловсруулалт, мэдээ зохиолт гэсэн 5 үзүүлэлтээр сар бүр дүгнэн зааварчилга, зөвлөмж өгч | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллахад, ажлын чанар үр дүнгээрээ Зүүнхараа, Орхонтуул, Цагааннуур, Сүхбаатар, Зүүнбүрэн өртөөд, харуул бусдыгаа манлайлан ажилласан байна.<br>2025 оны салбаруудын жилийн шинжилгээний ажлын дүн 99.4-99.7 хувь буюу дунджаар 99.77 %-тай дүгнэгдэж өмнөх оноос 0.4%-иар ахисан байна.<br>Шинжилгээний ажилд гарч буй алдааг засах, технологийг мөрдөн ажиллахад анхаарч салбаруудад сар бүр хариу зааварчилга бичиж хүргүүлснээс гадна УЦУОСМХ-ийн цаг уурын сектороос ирсэн 4, манай салбараас нийт 7 зөвлөмж хүргүүлсэн. Мөн шаардлагатай үед цахимаар холбогдон заавар зөвлөмж өгч ажилласнаар хөтөлбөрт шинжилгээний ажил цаг хугацаандаа бүрэн биелэгдлээ.<br>УЦУОСМХ-ийн цаг уурын секороос 1 дүгээр улирлын дүн А/Ч-99.6%, Ш/Ч-99.2%, 2 дугаар улирлын дүн 3 дугаар улирлын А/Ч-98.6%, Ш/Ч-97.2%, 4 дүгээр улирлын дүн А/Ч-98.8%, Ш/Ч-99.1%-тай дундаж дүн 98.8%-тай өмнөх оноос 0.6%-иар буурсан. Ажиглалтын чанар буюу шүүмжийн чанар буурсан гол шалтгаан нь Орхон өртөө, Баруунбүрэн харуулын чийг гологдол болсон ба эдгээр өртөө, харуулын чийгийн мэдрүүр гэмтсэн байсантай холбоотой. | 99,45% |
| 1.1.2 | Хөдөө аж ахуйн цаг уурын | | УЦУОСМХ-ийн ХААЦУС-ны | Ажиглалтын чанар-100%<br>Шүүмжийн чанар-100% | Ажиглалтын чанар-100% | Арав хоногийн агро дундаж мэдээ 36 удаа шалгаж, алдаагүй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай хийж гүйцэтгэх. | Улсын төсөв | хэлтсээс ирүүлэх ажиглалтын чанар, шүүмжийн чанарын дүн - хувиар | | Шүүмжийн чанар-100% | дамжуулахад хяналт тавьж, арав хоног бүрийн цас, ургамалжилтын зургийг Arcgis-д боловсруулж зураглалд оруулсан.<br>Бэлчээрийн ургамлын үе шат, ургамлын өндөр, гэмтлийн ажиглалтыг хашаалсан талбайн 7 өртөөнд 504 удаа, хашаалаагүй талбайн 6 харуулд 126 удаа, хөрсний чийгийн ажиглалтыг 6 өртөөнд 105 удаа, бэлчээрийн хортон шавьжийн ажиглалт 273 удаа, мэрэгчийн ажиглалт 39 удаа таримал ургамлын үзэгдэл зүйн ажиглалтын 6 станцад 594 удаа тус тус хэмжилт хийсэн.<br>ХААЦУ-ын ажиглалтын материалд 4-10 сарын ХД-1,1а 91ш, ХД-5 63ш, ХД-7б 91ш, ХД-2 42 ширхэг дэвтэрт, бэлчээрийн ургамлын 378 ширхэг, таримал ургамлын үе шатны 85 ширхэг хатаамалд техник болоод шүүмж шалгалт хийсэн. 2024 оны ХД-8 45 ширхэг дэвтэрт шүүмж шалгалт хийж, шивэлтийн ажлууд хийгдэж байна.<br>Тариалангийн талбайн хавар, намрын хөрс гэсэх хугацаа, хаврын угтвар нөөц чийгийн урьдчилсан мэдээ зохиосон.<br>4,10-дугаар сард тариалангийн талбайн хөрсний чийгийн явуул судалгааг 12 сумын уринш, гуурстай талбайд тодорхойлсон дүн мэдээг нэгтгэн гаргаж ХААЦУСХэлтэст хүргүүлсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөрсний автомат Баруунхараа, Цагааннуур өртөөний багажуудыг III/1, IV/1 нд тус тус байрлуулж, сар бүрийн **10, 20, 30/31**-ний өдрүүдэд мэдээг татан авч, агро дундаж мэдээнд 26 удаа кодлон дамжуулж, эх мэдээнд шүүмж шалгалт хийн, архивлан хадгалж байна. | |
| 1.1.3 | Ус судлалын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай хийж гүйцэтгэх. | Улсын төсөв | УЦУОСМХ-ийн ГУС-ын хэлтсээс ирүүлэх ажиглалтын чанар, шүүмжийн чанарын дүн - хувиар | т/б-99.98<br>ш/а/ч-95.8<br>ирц-99.7<br>урсац-97.5<br>нэгдсэн дүн-98.0 | т/б-100<br>ш/а/ч-95,9<br>ирц-100<br>урсац-97,3<br>нэгдсэн дүн-98.2 | Шинжилгээний ажлыг сайжруулах ажлын хүрээнд Сэлэнгэ-Сүхбаатар, Орхон-Сүхбаатар, Ерөө-Бугант, Ерөө-Ерөө ус судлалын шалган туслах ажлаар явж, багаж төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, шонгуудын засварыг гаргасан.<br>Ус судлалын 10 харуулын УД-1, УД-2, УД-5 дэвтрүүдэд техник болон шүүмж шалгалт хийж сар бүрийн 20-ны дотор УЦУСМХүрээлэнгийн Ус судлалын секторт цахимаар хүргүүлэн ажиллаж байгаа.<br>УХШ-100% | 100% |
| 1.1.4 | Орчны хяналт шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай явуулах. | Улсын төсөв | БОХЗТЛ-оос ирүүлэх ажлын дүн - хувиар | Ерөнхий үнэлгээ-100% | Ерөнхий үнэлгээ 100% | Сэлэнгэ мөрний Сэлэнгэ-Зүүнбүрэн, Сэлэнгэ-Сүхбаатар, Сэлэнгэ-Наушка хяналт-шинжилгээний цэгээс нийт 37 сорьц, Орхон голын Орхон-Орхон, Орхон-Шаамар, Орхон-Сүхбаатар хяналт-шинжилгээний цэгээс нийт 29 сорьц, Хараа голын Хараа-Зүүнхараа хяналт-шинжилгээний гүүрний дээд ба доод, Хараа-Баруунхараа хяналт-шинжилгээний цэгээс нийт 18 сорьц, Ерөө голын Ерөө-Бугант, Ерөө-Ерөө, Ерөө-Дулаанхаан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт-шинжилгээний цэгээс 25 сорьц, Бугант голын Бугант-Бугант хяналт-шинжилгээний цэгээс 7 сорьц, Зэлтэр голын Зэлтэр-Зэлтэр хяналт-шинжилгээний цэгээс 4 сорьц, Хүдэр голын Хүдэр-Хүдэр хяналт-шинжилгээний цэгээс 4 сорьц, Бууръ голын Бууръ-Сүхбаатар хяналт-шинжилгээний цэгээс 7 сорьц, Туул голын Туул-Орхонтуул хяналт-шинжилгээний цэгээс 8 сорьц, Хиагт голын Хиагт-Алтанбулаг хяналт-шинжилгээний цэгээс 7 сорьц, Бургалтай голын Бургалтай-Бургалтай хяналт-шинжилгээний цэгээс 4 нийт 145 сорьц авахаас 150 сорьц авагдсан. Бүрэн хийгдсэн. | |
| 1.1.5 | Цаг уурын 7 өртөө, 6 харуулын шуурхай мэдээг олон улсын болон бүсийн солилцоонд хяналтын хугацаанд бүрэн дамжуулах, байгууллагын сүлжээ ашиглалтын хэвийн ажиллагаа | Улсын төсөв | УЦУОСМХ-ээс ирүүлсэн сүлжээ ашиглалт, мэдээ дамжуулалтын дүн- хувиар | Сүлжээ ашиглалт-100%<br>Мэдээ дамжуулалт-99.98% | Сүлжээ ашиглалт-100%<br>Мэдээ дамжуулалт-100% | 7 өртөөний погод мэдээ 20272, харуулын мэдээ 6480 удаа, нийт 26,752 мэдээ дамжихаас 68 мэдээ хугацаанаас хоцорч, 61 мэдээ алдаатай дамжсан байна.<br>Өртөө, харуулын шуурхай мэдээ дамжилтын дүн 99.57%- тай байна. Өмнөх оны мөн үеэс 0,04 хувиар өссөн байна.<br>Сүлжээ ашиглалт 100% | 100% |
| 1.1.6 | Климат мэдээг хянах, шуурхай дамжуулах | Улсын төсөв | УЦУОСМХ-ээс ирүүлсэн климат мэдээний дүн-хувиар | Дүн 100% | Дүн 100% | 7 станцын 10 хоногийн болон сарын климат мэдээг 336 удаа шалгаж, дамжуулалтанд нь хяналт тавьж ирснээс чанар 100%-тай | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буюу өмнөх оноос өөрчлөлтгүй байна. | |
| 1.1.7 | Аюул агаар мэдээг хянах, шуурхай дамжуулах | Улсын төсөв | УЦУОСМХ-ээс ирүүлсэн аюул агаар мэдээний ирц, чанарын дүн- хувиар | Ирц 100%<br>Чанар 100 % | Ирц 100%<br>Чанар 100 % | Цаг уурын станц, харуулуудаас зохиож ирүүлсэн байгаль, ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн 306 аюул агаар мэдээнд хяналт тавьж шалгасан байна.<br>Ирц 100% буюу өмнөх оны дүнтэй харьцуулахад өөрчлөлтгүй байна. Чанар нь 100% буюу өмнөх оны дүнтэй харьцуулахад өөрчлөлтгүй байна.<br>Аюул агаар мэдээний ерөнхий дүн нь 100% буюу өмнөх оны дүнтэй харьцуулахад өөрчлөлтгүй байна.<br>• Орон шуурга 164 удаа<br>• Нойтон цас 164 удаа<br>• Хүчтэй салхи 78 удаа<br>• Агаарын даралт 14 удаа<br>• Шороон шуурга 8 удаа<br>• Нөөлөн салхи 2 удаа<br>• Мөндөр 1 удаа | 100% |
| 1.1.8 | Багаж, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулгыг хийнэ. | Улсын төсөв | Баталгаажуулсан автомат станцын тоо, харуулын автомат багажийн тоо | Нийт 8 автомат станц, 5 автомат багажийн баталгаажуулалт хийгдсэн. | Нийт 7 автомат станц, 5 автомат багажийн баталгаажуулалт хийгдсэн. | Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, /шалгалт тохируулгын/ -ын ажлын 2025 оны график төлөвлөгөөг батлуулан ажиллалаа.<br>Графикийн дагуу: Агаарын даралтын болон чийг температурын зөөврийн шалгалтын багажийг БОХЗТЛ-д баталгаажуулалт хийлгэж гэрчилгээ сунгуулав.<br>Ерөө, Цагааннуур, Сүхбаатар, Баруунхараа,Ерөө, Зүүнхараа, Орхон станцуудад | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харьцуулсан тоололт хийж баталгаажуууллаа. Харуулуудад суурилуулсан автомат багаж бүхий Зэлтэр, Хушаат, Баруунбүрэн. Бугант, Хүдэр сумдад харьцуулсан тоололт хийлээ. Цацрагийн багажийн хэмжилтийг Улаанбаатар хотод Цөмийн энергийн комиссын ажлын албаны дозиметр тохируулга, баталгаажуулалтын лабораторит 2025 оны 4 дүгээр сарын 7-ны 14.00 цагаас эхлэн түр зогсоож баталгаажуулалтанд илгээж, 2025 оны 4 дүгээр сарын 12-ны 15.00 цагт ирж, 2025 оны 4 дүгээр сарын 13-ны 08.00 цагаас эхлэн мэдээ дамжуулалт хэвийн үйл ажиллагаанд орсон. Аналитик болон электрон жин, автомат пипеткийн тохируулгыг 2025 оны 05 дугаар сарын 27-нд Сэлэнгэ аймгийн Стандарт Хэмжил зүйн хэлтсийн шалгалт тохируулгын мэргэжилтнээр хийлгүүлж, гэрчилгээ авсан. Спектофотометр, pH метр, кондуктометрийг Улаанбаатар хотын СХЗГ-ын “Б” байранд 2025 оны 10 дугаар сарын 16-нд баталгаажуулалтанд хамруулж гэрчилгээг авсан. | 100% |
| 1.1.9 | Тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийн засвар, үзлэг | Улсын төсөв | БОХЗТЛ-оос ирүүлэх ажлын чанарын дүн, хувиар | Ажлын чанар-99,67% | Ажлын чанар-99.67% | Өртөө харуулуудын тасралтгүй ажиллагааг хангах, багаж төхөөрөмжийг технологийн зөрчилгүй бүрэн ажиллуулахад | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг тогтмол хийх | | | | | анхааран засвар үйлчилгээг тогтмол хийн ажиллаж байна.<br>2025 онд нийт 15 удаагийн засварлалтын ажлыг гүйцэтгэн багаж төхөөрөмжид гарсан эвдрэл, гэмтэл, үл тохирлыг илрүүлэн шуурхай арга хэмжээ авч ажиллалаа. | 100% |
| 1.1.10 | Төрийн архивын үйл ажиллагааг стандартын дагуу хэвийн явуулах. | Улсын төсөв | ЦУОШГ, АМСХ-ээс ирэх архивын дүн - хувиар | Архивын дүн- 99.4% | Архивын дүн- 99.6% | 2025 онд АМДС-д хүлээн авах цаасан суурьтай баримтыг хөмрөг үүсгэх хуваарийн дагуу УЦУОШТөвийн Уур амьсгал боловсруулалтын салбараас 50 хн 12515, ХААЦУ-ын салбараас 37 хн 2402, Ус судлалын салбараас 19 хн 3810, Байгаль орчны шинжилгээний лаборатори 8 хн 1201 хуудас шинжилгээний материалыг тус тус хүлээн авч цэгцлэн санд оруулсан. Нийт 114 хадгаламж нэгж, 19928 хуудас мэдээ шинээр оруулсан. Нийт хадгаламжийн тоо 3877 хн, баримтын 645394 хуудас тоотой хадгалагдаж байна.<br>2024 оны 7 өртөөний термографийн 2562ш, гигрографийн 2562ш, барографийн 345ш өөрөө бичигчүүдийн нийт 5469ш туузыг скайнердаж баримтын бүртгэл хийсэн. Ус цаг уур, Баримтын төв, Төрийн төрөлжсөн архив WAMS-программд шивж оруулж өгсөн. 1988-1990 оны цаг уурын ажиглалтын ЦД-1 дэвтрийг скайнердаж, Ус цаг уур , Баримтын төв, Төрийн төрөлжсөн архив WAMS-программд шивж оруулж өгсөн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны жилийн эцсийн байдал дүнгээр 99,6% өмнөх оны дүнтэй харьцуулахад 0,2 %-аар өссөн байна. | |
| 1.1.11 | Мэдээллийн дэд сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах, дэд санд нөхөн бүрдүүлэлт хийх | Улсын төсөв | ЦУОШГ, АМСХ-ийн мэдээллийн дэд сангийн нэгдсэн дүн, хувиар | Мэдээллийн дэд сангийн дүн 100% | Мэдээллийн дэд сангийн дүн 99,92% | Цаг уурын 7 өртөөний 2024 оны 11-12 дугаар сарууд, 2025 оны 1-10 дугаар сарын автомат станцын горимын мэдээ 7 хн 302 мв нийт 77 хн, 1.56.GB хэмжээ бүхий мэдээг хүлээн авч шалган сар бүрийн 10-ны дотор сүлжээгээр АМСХ-т хүргүүлсэн.<br>Сүхбаатар өртөөний автомат станцын 5 сарын 1 хоногийн мэдээ ftp хуулахдаа 1 хоног дутуу хуулагдснаас шалтгаалан -0,08 оноо хасагдсан. | 99,92% |
| 1.2 Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох ган, цөлжилтийн эрсдэлийг бууруулах, таримал болон бэлчээрийн ургамлын ургацыг нэмэгдүүлэх, ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэхэд агаар мандлын үзэгдэл, процесст зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх, агаар, ус, хөрсний чанарт хяналт шинжилгээ хийх үйл ажиллагаа | | | | | | | |
| 1.2.1 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг оновчтой зөв зохион байгуулах, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашгийг дээшлүүлнэ; | Улсын төсөв, Орон нутгийн төсөв 30сая төгрөг | Орох хур тунадасны хэмжээ нэмэгдэж хуурайшилт багасч ой, хээрийн түймэр гарахгүй байх нөхцлийг бүрдүүлэн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажилласан байна. | 99,73 % | 99,75 % | Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийн үйл ажиллагааг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын А/26 тоот тушаалын дагуу эхлүүлж экспедицийн аюулгүй ажиллагааны заавар танилцуулж, гарын үсэг зуруулан харвалт хийсэн үеийн акт, код мэдээг тухай бүрт нь шуурхай дамжуулж байв.<br>2024 оны үлдэгдэл 16 ширхэг пуужинтай үйл ажиллагаагаа эхлүүлж нэмэлтээр 2025 оны 4-р сарын 15-нд 10 пуужин, 5 сарын 13 -нд 26, 6 сарын 23-нд 40 ширхэг, 7 сарын 7- нд 20 ширхэг, 7 сарын 20-нд 40 ширхэг пуужинг тус тус нэмэлтээр авч ажилласан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Одоогийн үлдэгдэл 24 ширхэг пуужин байна.<br>ЦУОШТөвийн даргын тушаалаар Сэлэнгэ Бороо -1,2,3, экспедицүүдийн бие бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 3 дугааар сарын 25, 4 дүгээр сарын 03, 22, 25-ны өдрүүд 5 дугаар сарын 11, 12, 14, 19, 20, 28, 29-ний өдрүүд, 6 дугаар сарын 10, 13, 26, 27 28 29-ний өдрүүд, 7 дугаар сарын 02, 03, 08, 09, 10, 15, 17, 21 ,23, 24, 31, 8 дугаар сарын 01, 04, 05–ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн нутагт үүлэнд зориудаар нөлөөлөн хур тунадас нэмэгдүүлэх, хөрсний чийгийг сайжруулах ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх, ургамлын ургалтыг тэтгэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор цаг агаарын нөхцөл бүрдсэн 21 удаагийн гаралтаар 30 процесст 62 удаагийн хээрийн ажиллагаа явуулж 124 ширхэг бороохы пуужин харваж цаг агаарт зориудаар нөлөөлж болох бүх нөхцлийг алдалгүй гарч ажилласан болно.<br>Пуужин хадгалах байранд тогтмол цэвэрлэгээ хийж, агаарын чийг, температурыг шалгаж тэмдэглэл хөтлөн ажиллалаа. Мөн экспедиц ажиллах үед агуулахаас гаргасан пуужинг ЦАЗН ерөнхий инженерт хариуцуулж пуужин гаргасан, хүлээлгэн өгсөн бүртгэл хийсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг орон нутгаас дэмжин хамтран ажилладаг бөгөөд аймгийн ЗДТГазартай гэрээ байгуулан 30 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулан тухай бүрт тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.<br>Үйл ажиллагаа эхлэхийн өмнө 3 экспедицийн харвах төхөөрөмж, удирдлагын пульт, радарын станц, машин техникт засвар үйлчилгээ хийн сэлбэг хэрэгсэл авч ажилд бэлэн болгосон.<br>Цаг агаарт зориудаар нөлөөлөх инженерийн сургалтанд тус төвөөс 4 хүн суралцан төгсөж “Тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэх” авсан. | |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ -2.1. УС ЦАГ УУР, ОРЧНЫ НИЙТИЙН МЭДЭЭГЭЭР ХЭРЭГЛЭГЧДЭД ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ҮЙЛЧЛЭХ | | | | | | | |
| 2.1.1 | Цаг уурын бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, цуглуулах, дотоодын болон олон улсын солилцоонд гаргах ажилд ашиглагдаж байгаа компьютер, сүлжээний техник, тоног төхөөрөмжийн | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувиар | Компьютер, сүлжээ, интернетийн ажиллагаа тасралтгүй хэвийн явагдсан 100% | Компьютер,тоног төхөөрөмж, сүлжээний ажлын хэвийн байдал алдагдаагүй байна. 100% | Төвийн болон салбар нэгжүүдэд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үзлэг үйлчилгээг тогтмол хийж байна. Тоног төхөөрөмжид үзлэг үйлчилгээ хийх календарчилсан төлөвлөгөө гарган, төвийн даргаар батлуулж, хуваарийн дагуу үзлэг үйлчилгээг хийж бүртгэл хөтлөн ажиллалаа.<br>2025 онд энэ ажлын хүрээнд 28 удаагийн үзлэг үйлчилгээ хийсэн байна. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тасралтгүй, шуурхай байдлыг хангаж ажиллах | | | | | - Дотоод сүлжээ ажиллахгүй болсон 10 компьютерийг хэвийн болгосон<br>- Персона мисс ажиллахгүй болсон- 5 компьютерийг хэвийн ажиллагаатай болгосон.<br>- Үйлдлийн систем 3 компьютерт суулгасан.<br>- Вирусны программын сунгалтыг 15 компьютерт хийж, 4 удаа программ шинэчилж суулгав.<br>- Оффисын программ шинэчилж 10 компьютерт суулгав.<br>- Принтер, сканнер гэх мэт төхөөрөмжүүдийн доголдлыг тухай бүрт засаж залруулж ажилласан.<br>- Бусад программ болон техникийн асуудал үүссэн компьютеруудын хэвийн үйл ажиллагааг тухай бүрт нь хэвийн ажиллагаатай болгон засаж ажиллалаа.<br>- Баруунхараа цаг уурын ажиглалтын компьютер систем гэмтсэн тул алдааг засаж хэвийн ажилд оруулав.<br>- 21 аймгийн сүлжээг сайжруулах ажлын хүрээнд манай аймагт UNITEL ХХК-ийн модем тавиулж, тохиргоо хийн нэгдсэн сүлжээнд холбогдоход бэлэн болсон.<br>Цаашид ЦУОШГ-аас ISP тохиргоо хийсний дараа бүрэн сүлжээнд орохоор хүлээгдэж байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Цаг агаарын төрөл бүрийн урьдчилсан мэдээ, тойм зөвлөмжөөр төрийн байгууллага, аж ахуйн нэгжид үйлчлэх | Улсын төсөв | Үйлчилгээний тогтмолжилт, хэлбэр, хүрээ | 100% | 100% | Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг ард иргэдэд, малчдад-малчны хотонд, аж ахуйн нэгжид-тариан талбайд сүлжээ харгалзахгүйгээр MASS мессежээр шуурхай хүргэн ажилласан.<br>Цаг агаарын мэдээ мэдээллийг “Гэрлэн самбарт” тогтмол гаргасан.<br>Зүүнхараа хотод 1-5 хоногийн урьдчилсан мэдээг өдөр бүр зохиож УМС-т өгч Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр тогтмол мэдээллэсэн.<br>**Мессеж мэдээгээр үйлчилсэн байдал:**<br>Тус төвөөс нийтдээ 13 суманд масс мессэж үйлчилгээ ашиглагдаж байгаад сүүлийн жилүүдэд ашиглахаа больсон ба сүүлд аймгийн төв болон Бугант тосгоноос л масс мессэж үйлчилгээ олон нийтэд хүргэдэг байж байгаад энэ оны 2 дугаар хагасаас Бугант тосгон энэхүү үйлчилгээг ашиглахаа больсон.<br>Бүх сумдын цаг уурын станц, харуулууд weather.gov.mn, Сэлэнгэ аймгийн УЦУОШТөв гэсэн page болон group чатууд, viber, mail, утсаар мэдээллээ хүргэдэг болсон. Харин төв цаг уураас 6-р сард нийт 153 хүнд их бороо сэрэмжлүүлэг мэдээгээр 2 удаа буюу 306 хүнд, 7-р сард нийт 162 хүнд их борооны сэрэмжлүүлэг мэдээгээр 332 хүнд, 8-р сард нийт 149 хүнд их борооны сэрэмжлүүлэг мэдээг 3 удаа буюу | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 447 хүнд буюу нийтдээ жилийн эцсийн байдлаар Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГазрын дарга, ИХТөлөөлөгчдийн дарга, ХХААЖДҮГазрын дарга, ОБГазрын дарга болон орлогч дарга нар болон бүх сумдын засаг дарга, иргэд, тариаланчид, малчид бүхий иргэд гэх мэт давхардсан тоогоор 325 хэрэглэгчдийн гар утсанд сүлжээ харгалзахгүйгээр 4426 удаа мессежээр цаг агаарын урьдчилсан мэдээг шуурхай хүргэн ажиллалаа. | |
| 2.1.3 | Нарийвчилсан мэдээ, 1 хоног, 5 хоногийн урьдчилсан мэдээг тасралтгүй, чанартай бичиж үйлчлэх. | Улсын төсвөөр | НМ+ХМ+5ХМ= дундаж таарц, хувиар | Нарийвчилсан мэдээний ирц -100%<br>Хоногийн мэдээний ирц-100%<br>Нарийвчилсан мэдээний таарц- 96,0%<br>Хоногийн мэдээний таарц- 92,9%<br>1-5 хоногийн мэдээний таарц- 87,0%<br>Цаг агаарын урьдчилсан мэдээний ерөнхий таарцыг 95,2%- | Нарийвчилсан мэдээний ирц -100%<br>Хоногийн мэдээний ирц- 100%<br>Нарийвчилсан мэдээний таарц- 96,7%<br>Хоногийн мэдээний таарц- 94,7%<br>1-5 хоногийн мэдээний таарц- 87,3%<br>Цаг агаарын урьдчилсан мэдээний ерөнхий таарцыг 87,3% | **Хагас хоногийн урьдчилсан мэдээний ирц, таарц**<br>Сүхбаатар сумын цаг агаарын хагас хоногийн урьдчилсан мэдээг 365 удаа зохиож 96,7%-ийн таарцтай буюу энэ оны зорилтот түвшинтэй харьцуулахад 0.7 %-аар өссөн ирц нь 100 %-тай буюу өмнөх оны дүнтэй харьцуулахад өөрчлөлтгүй байна.<br>**Хоногийн урьдчилсан мэдээний ирц, таарц**<br>Сүхбаатар сумын цаг агаарын хоногийн урьдчилсан мэдээг 365 удаа зохиож 94,7 %-ийн таарцтай буюу энэ оны зорилтот түвшинтэй харьцуулахад 1.8 %-аар өссөн, ирц нь 100 %-тай байна.<br>**1-5 хоногийн урьдчилсан мэдээний ирц, таарц**<br>Сүхбаатар сумын цаг агаарын 1-5 хоногийн урьдчилсан мэдээг 365 удаа зохиож 87,3 %-ийн таарцтай буюу энэ оны зорилтот түвшинтэй | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харьцуулхад 0.3 %-аар өссөн, ирц нь 100 %-тай байна. | |
| 2.1.4 | Нислэгийн мэдээгээр үйлчлэх. | Улсын төсөв | Нислэг бүрт | Ажлын чанар 99,9% | Ажлын чанар 98,21% | 2025 оны жилийн эцсийн байдлаар 447 удаагийн нислэгт цаг агаарын 1060 мэдээгээр үйлчилсэн байна.<br>TAF TOIM-ыг 417 удаа<br>Районы урьдчилсан мэдээг 350 удаа, угталтын урьдчилсан мэдээг 6 удаа, чиглэлийн урьдчилсан мэдээг 287 удаа тус тус бичиж нисэхийн цаг уурын төвд дамжуулсан байна.<br>Шуурхай үйлчилгээний дүн 100%, мэдээ зохиолтын чанар 90.5%, шуурхай зохицуулалт 100%, ачааллын коэффициент 1.4%-тай байна. Ерөнхий дүн 98.21% байна. | 98% |
| 2.1.5 | Архивын баримт, тусгай хэрэгцээний мэдээгээр байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийн хүсэлтээр үйлчлэх. | Улсын төсөв | Шийдвэрлэлтийн хувиар | Ажлын чанар 100% | Шийдвэрлэлтийн дүн-100% | Албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэдэд захиалгын дагуу 2025 оны байдлаар төлбөртэй 15 мэдээгээр үйлчилсэн. | 100% |
| 2.1.6 | Цаг агаарын тусгай хэрэгцээний урьдчилсан мэдээгээр хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэн үйлчлэх. | Улсын төсөв | Шийдвэрлэлтийн хувиар | - | Шийдвэрлэлтийн дүн-100% | **Тусгай хэрэгцээний урьдчилсан мэдээгээр хэрэглэгчдэд үйлчилсэн байдал:**<br>Цаг агаарын мэдээ мэдээллээр 58 аж ахуйн нэгж, иргэдэд мэдээ мэдээллээр үйлчилж хамтран ажиллахын зэрэгцээ цаг агаарын урьдчилсан мэдээ болон тойм зөвлөмжөөр нийт 26 засаг захиргааны нэгж, байгууллагад үйлчлээд байна.<br>Мөн цаг агаарын нөхцөл байдлын тодорхойлолтыг аж ахуйн нэгж, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрийн байгууллагад нийт 7 удаа бичиж холбогдох газруудад шуурхай хүргүүлж ажиллалаа.<br>- Өвлийн бэлчээрийн цасны явуул судалгааны ажиглалтыг 17 сумын 45 зогсоол цэгт хийж, мал өвөлжилтийн тойм, зудын үнэлгээ хийж, зураглалд оруулан, ард иргэдэд үйлчилсэн.<br>- Хөрс гэсэх хугацаа, хөрсний хаврын угтвар ашигтай чийгийн урьдчилсан мэдээ зохиож, мэдээний таарц 89,7%-тай буюу өмнө жилээс 0.1%-аар ахисан.<br>- Хөрс гэсэх, хөлдөх хугацааны явуул судалгаагаар 4,10-р сард 11 сумын 22 талбайд хөрсний угтвар чийгшил тодорхойлж, дүн мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн ХААГазар, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд, мөн газар тариалан эрхэлдэг иргэд болон тариаланчдын зөвлөгөөнд хөрсний чийгийн мэдээгээр үйлчилсэн.<br>- Сар бүрийн 11, 21, 1-ний өдөр өртөө, харуулаас арав хоногийн агро дундаж мэдээг 36 удаа хүлээн авч, цасны дундаж зузаан, агаар, хөрсний температур, бэлчээрийн ургамал, хөрсний чийгшил, хөнөөлт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | царцаа, мэргэчдийн ажиглалт, мал аж ахуй, газар тариаланд зохиогдож буй тоймыг **http://selenge.weather.gov.mn/** сайтанд байршуулж үйлчилсэн.<br>- Бэлчээрийн төлөв байдлын ажиглалтаар 17 сумын 45 зогсоол цэгт хийж, 2025-2026 оны бэлчээрийн даац багтаамжийг тодорхойлон, хүснэгт, зураглал гарган аймгийн ХААГазар, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүдэд мэдээллэхийн зэрэгцээ сайтад байршуулан ажилласан. | |
| 2.1.7 | Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээний чанарыг сайжруулах, аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилан илрүүлэлтийг нэмэгдүүлэх. | Улсын төсөв | АҮ, ГҮ-ийн СМ, УСМ бичих нөхцөл бүрдсэн тохиолдол бүрт | Таарц 95,0%, онч 98,2%, урьдчилан илрүүлэлт 100%, | Таарц 95.1%, онч 98.8%, урьдчилан илрүүлэлт 100%, | 202**5** он**д** аюултай үзэгдэл болон гамшигт үзэгдлээс сэргийлэх мэдээ зохиох цаг агаарын нөхцөл 24 удаа бүрдсэнээс, 24 удаагийн сэрэмжлүүлэх мэдээ бичиж ажиллалаа.. Үүнд:<br>• Цочир хүйтрэлтээр 6 удаа<br>• Цасан шуурга 8 удаа<br>• Хүчтэй салхи 2 удаа<br>• Их бороо 2 удаа<br>• Их цас 5 удаа тус тус бичиж чанар нь 95,1 %-ийн таарцтай, онч 98,8%, илрүүлэлт 100% байна. Өмнөх оны дүнтэй харьцуулахад таарц 0,1%-аар өссөн, онч 0,6%-аар өссөн, илрүүлэлтийн хэмжээ өөрчлөлтгүй байна. Сэрэмжлүүлэг мэдээний | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ерөнхий дүн нь 97.97% байгаа нь энэ оны зорилтот түвшний дүнтэй харьцуулахад 0,2 %-аар өссөн дүнтэй байна. | |
| 2.1.8. | Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээгээр үйлчлэх. | Улсын төсөв | Анхааруулага мэдээний тоо | Анхааруулага мэдээ бичих нөхцөл бүрдсэн тохиолдол бүрт | Анхааруулага мэдээ бичих нөхцөл бүрдсэн тохиолдол бүрт | 2025 онд анхааруулах мэдээг ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, малчид, ногоочид, тариаланчид, тээвэрчдэд зориулан нийт 248 удаа бичсэн. Үүнд:<br>• Хүйтрэлт 26 удаа<br>• Цасан болон шороон шуурга 36 удаа<br>• Цочир хүйтрэлт 11 удаа<br>• Салхи шуурга 14 удаа<br>• Их цас 3 удаа<br>• Халалт 12 удаа<br>• Нойтон цас 9 удаа<br>• Шар усны үерийн мэдээ 10<br>• Ой хээрийн түймэр 30 удаа<br>• Хуурайшилт 22 удаа<br>• Цаг агаар тогтуун байх тухай 5 удаа<br>• Нөөлөг салхи 9 удаа<br>• Дуу цахилгаантай аадар бороо 45 удаа<br>• Гол мөрний мөс цөмрөх үеийн мэдээ 16 удаа тус тус бичиж хэрэглэгчдэд үйлчилсэн байна. | 100% |
| 2.1.9 | Цахим орчинд ус, цаг уур, байгаль орчны мэдээ, мэдээллээр ард | Улсын төсөв | Мэдээлэл цаг хугацаандаа бүрэн тавигдсан эсэх хувиар. | 100% | 100% | Манай төвийн 6846 гаруй дагагчтай Сэлэнгэ цаг уурын төв, Сэлэнгэ аймгийн УЦУОШТөв нэртэй 2 пэйж хаягийг хөгжүүлэн мэдээ мэдээллээ тогтмол тавин үйлчилж байна. Тус пэйжүүдээр 36 төрлийн мэдээ | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдэд үйлчлэх | | | | | мэдээллүүдийг давхардсан тоогоор 581053 хүн үзэж хандсан байна. | |
| 2.1.10 | Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр дээрхи гадаргын ус болон байгаль орчны төлөвийн мэдээллээр үйлчлэх түгээх, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх; | Улсын төсөв | Мэдээлэл тоо, хувиар | ХААЦУ,<br>Ус судлал,<br>БОШЛ-ын удаа шаардлагатай төрөл бүрийн мэдээгээр үйлчилж хэлбэр, хүрээг өргөтгөн ажилласан | 100% | Байгаль орчны шинжилгээний лабораторид 25 удаа шаардлагатай төрөл бүрийн мэдээгээр үйлчилж хэлбэр, хүрээг өргөтгөн ажилласан**.** /https://selenge.weather.gov.mn/environmental сайтад агаарын чанарын 10 хоногийн мэдээ 36, агаарын чанарын сарын мэдээ 12, гадаргын усны чанарын сарын мэдээ 12, хаягдал усны чанарын мэдээ 12 удаа тус тус нийтэлж ажиллалаа.<br>Мөн энэ онд Сүхбаатар, Мандал сумын агаарын чанарын хоногийн болон долоо, хоног сарын тойм мэдээг видео хэлбэрээр бэлтгэн хүргэсэн. Тус мэдээллүүд нийт 3518 хандалттай байна.<br>ГУСХэлтэст сарын мэдээлэл үйлчилгээний тайланг дамжуулсан.<br>Үүний зэрэгцээ http://selenge.tsag-agaar.gov.mn/ сайтад усны түвшний болон м**өс**ний зузаан үзэгдлийн тойм мэдээг 10 хоног тутам нийтдээ 34 удаа байршуулсан.<br>Сэлэнгэ аймгийн нутгаар урсан өнгөрөх голуудын мөсний зузааны мэдээг арав хоног бүрээр шинэчлэн байгууллагын вэб хуудас болон сайтуудад байршуулан ард иргэд, албан байгуулгуудад мэдээллэсэн.<br>Мөн инженерийн хамт Сэлэнгэ-Сүхбаатар усны харуул дээр мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх мэдээгээр | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **рийл** хийж олон нийтэд мэдээллэсэн.<br>ХААЦУ 201 удаа мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. | |
| ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ -2.2. Хүрээлэн буй байгаль орчны төлөв байдалд хяналт тавьж үнэлэх, судлах ажлын хүрээг өргөжүүлэх | | | | | | | |
